



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

“Хосмөнх инвест ББСБ” ХХК-ийн банк бус  
санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хосмөнх инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг “Хосмөнх инвест ББСБ” /Ч.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-д тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001058